

**СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2021 оны 02 дугаар сарын мэдээлэл

2021.02.23.

Төрийн удирдлагын чиглэлээр:

ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлыг 2021.02.18 ны өдөр хуралдаж дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1.Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах хэсгийн нутаг дэвсгэр төвийг тогтоох тухай. Зурагт болон ухуулах хуудас байршуулах, байршил тогтоох тухай • ИТХ-ын бүтэц, орон тоо батлах тухай • Дарьганга тохижилт үйлчилгээ /ОНӨААТҮГ/-ын бүтэц, орон тоо цалингийн санг шинэчлэн батлах тухай асуудлуудыг хэлэлцэн баталсан.

2.ИТХ-ын ажлын албанд Алдарт эхийн I , II зэргийн одон авах эхийн материалыг хүлээн авч байна.

3. Сумын Засаг даргын захирамжаар цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Тамгын газрын даргаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй, Агаар бохирдлын эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг 15 хүний, Үйлчилгээний газруудад хяналт шалгалт , хууль эрх зүйн сурталчилгаа зохион байгуулах ажлын хэсгийг Цагдаагийн хэсгийн төлөөлөгчөөр ахлуулан 5 хүний бүрэлдэхүүнтэй тус тус томилон ажиллалаа. Сар шинийн баярыг тохиолдуулан “ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлж хөдөлгөөний тэг зогсолтын арга хэмжээг авч, эргүүл постыг ажиллуулсан.

4. Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга хамтран ажиллах гэрээ, аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллах гурвалсан гэрээг 2021.02.24 ний өдөр Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотноо “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ний үед байгууллаа.

5. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Дотоод хяналт, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын төлөвлөгөөнүүдийг сумын Засаг даргаар тус тус батлууллаа.

6. Нийтийн албан тушаалтан 10 хүний ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулж, тайлан мэдээг аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.

7. Цахим үйлчилгээний нэгдсэн төвийн операторч нь хоёрдугаар сард 7 төрлийн үйлчилгээг 13 иргэнд үзүүлсэн.

8. Сумын хөгжлийн индексийг тодорхойлох 42 шалгуур үзүүлэлтийн хүрээнд судалгааг нэгтгэн цахимд орууллаа.

Сургалт сурталчилгааны чиглэлээр.

- Дотооддоо сургалт сурталчилгааны төлөвлөгөөний дагуу Угийн бичиг хөтлөлтийн сургалтыг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 18 албан хаагчдад зохион байгууллаа. Хуваарийн дагуу бүх байгууллагуудад зохион байгуулна.

- Сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран “Цагаан сар нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулж, “Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар” гэсэн пэйж хуудсанд 84 төрийн албан хаагч нэгдлээ. Мөн албан байгууллагуудын гамшгийн үеийн бэлэн байдлыг 11 үзүүлэлтээр хянан шалгах арга хэмжээг зохион байгуулж, дүгнэлт хийсэн.

- Гаднаас төрийн албан хаагчид Нийгмийн даатгал, Хөдөлмөр нийгмийн халамжийн үйлчилгээ, Хүүхэд гэр бүл, татвар, Улсын бүртгэл, Газрын албаны чиглэлээр цахим сургалтуудыг хийсэн.

- “Олон улсын төслийн санал боловсруулах чадавхийг бэхжүүлэх нь” цахим сургалтад хууль эрх зүйн мэргэжилтэн хамрагдаж мэдээлэл авсан.

Сургууль, цэцэрлэгийн талаар

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2020 оны А/17, А/140, А/220, 2021 оны А/24 дүгээр тушаалууд, Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны А/106 дугаар захирамж, Сүхбаатар аймгийн БСУГ-ын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалыг тус тус мөрдлөгө болгон сумын 1, 2, 5, 9 дүгээр ангийн сурагчдын танхимын давтлагыг 2021 оны 02 дугаар сарын 18 ны өдрөөс албан ёсоор эхлүүлж 87 сурагч хамрагдахаас 66 сурагч хамрагдаж 76 % тай байна.

2021 оны 03 дугаар сарын 01 нээс эхлэх сургууль, цэцэрлэгийн танхимын хичээл эхлэхтэй холбогдуулан зохих журмын дагуух арга хэмжээг авч эхлээд байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

“Осол гэмтлээс сэргийлэх” хөтөлбөр төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хором бүрээ хяная” нэг сарын аяныг өрнүүлэн ажиллаж, аяны хүрээнд сурталчилгааг 88 иргэнд хүргээд байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын 4 багийн 373 хот айлын 224131 толгой мал хаваржина. Төллөх эх мал нь ингэ 38, гүү 7974, үнээ 8501, эм хонь 50508, эм ямаа 29329 нийт 96350 эх мал төллөнө.

Том малын зүй бус хорогдол адуу 31, үхэр 81, хонь 506, ямаа 537 нийт 1155 толгой малын хорогдолтой байна.

Бог малын хээлтүүлэгчийг ялган 5 суурь болгон суурилсан. 4, 1-р багт байгаа богийн хээлтүүлэгчийн суурь нь бэлчээрийн хомсдолоос болж богийн хээлтүүлэгчийн хорогдол нилээд гарч байна. Өнөөдрийн байдалаар цас хайлж мөстсөнөөс мал бэлчээрлэхэд нилээд хүндэрч байгаа нь хаваржилт хүндрэх төлөвтэй байна. Мөн 3,4 багийн өрхүүд бэлчээргүй болсоны улмаас хаваржаандаа бууж байна.

Өвсний фондод нөөцөлсөн 72 тн өвсийг малчдад тараан өгөх ажлыг зохион байгуулаад байна.

Байгаль хамгаалах чиглэлээр:

-Агаар бохирдлын эх үүсвэрийн тооллогын ажлыг зохион байгуулж байна. – Аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийх, хууль эрх зүйн сурталчилгаа хийх ажлын хэсгээс аж ахуйн нэгжүүдтэй хог хаягдлын гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй 47 ажил хайгч иргэний мэдээллийг сэргээсэн.

Ажил хайгч иргэний цахим анкет бөглөх холбоосыг сумын цахим группт байршуулсан.

2015-2020 оны хооронд малжуулах хөтөлбөрт хамрагдсан малчдын судалгааг гаргасан.

Нийгмийн халамжийн талаар:

Нийгмийн халамжийн цахим системд бүртгэлтэй насны хишигт хамрагдах 129 иргэн, алдарт эхийн одонд хамрагдсан 236 иргэн, Wais системд бүртгэлтэй нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэний мэдээллийг тулгасан.

Мөн И-халамж системд үйлчилгээ авагч 94 иргэний дансыг харилцагч банкттай тулгаж, 5 иргэний овог нэрийн зөрчлийг арилгуулсан.

Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимд системд хөрвүүлж байгаатай холбогдуулан халамжийн тэтгэвэр авагч 71 иргэний данс, утасны дугаарыг бүртгэж, иргэний мэдээллийг шинэчилсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийг 2 удаа хуралдуулж, ахмад настны асаргаанд шинээр 1 иргэн, асаргааны сунгалт 6, мөн хаврын тэргүүн сар, сар шинийн баярын хүндэтгэлд хамрагдах албан байгууллагын харъяалалгүй ахмадыг хэлэлцсэн.

Албан байгууллагын харъяалалгүй 239 ахмадын нэрсийг Wais программд бүртгэсэн.

Жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр.

1. Коронавируст халдвар-ны цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор спиртийн өндөр агууламж /18 градусаас дээш/ бүхий согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон хугацааг 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийг дуустал сунгасантай холбоотойгоор хэсгийн төлөөлөгчөөр ахлуулсан ажлын хэсэг аж ахуйн нэгжүүдээр явж согтууруулах ундааг худалдахыг хориглож лацдаж тусгаарласан.

2. Шинэ “Коронавирс” –ээс шалтгаалан үүсэж болзошгүй хүнсний хомстлоос сэргийлж долоо хоног бүр хүнсний дэлгүүр аж ахуй нэгжүүдээс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгааг авч байна. Үүнд:

ДАРЬГАНГА СУМАН ДАХЬ ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОДИТ НӨӨЦИЙН СУДАЛГАА

Хугацаа: 2021 он 02 сар

Хугацаа	Гурил /кг/	Гурилан бүтээгдэх үүн /600 гр/	Төрөл бүрийн будаа /тн/	Хуурай сүү /кг/	Өндөг /50 гр/	Ургамлын тос /кг/	Төмс/тн/	Хүнсний ногоо /тн/	Элсэн чихэр /тн/	Давс /0.5	Савласан ус /л/
2021 он 02 сар 01	11.95	1591	4.67	0.898	0.019	0.616	1075	1450	1530	0.675	0.920
2021 он 02 сар 04	9.8	2.071	13.83	1.818	0.07	1.17	1.925	1.525	6.475	0.825	1.06
2021 он 02 сар 08	9.35	2.112	13.7	1.66	0.046	1.096	1.65	1.48	6.411	0.815	1.04
2021 он 02 сар 10	9.35	2.12	13.7	1.653	0.046	1.089	1.61	1.48	6.406	0.8	1.02
2021 он 02 сар 15	9.35	2.112	13.7	1.66	0.046	1.096	1.65	1.48	6.411	0.815	1.04
2021 он 02 сар 18	7.025	1.363	3.13	0.812	0	0.454	0.15	0.25	1.45	0.55	0.628
2021 он 02 сар 22	7.02	1.425	3.11	0.811	0	0.448	0.12	0.24	1.45	0.55	0.628

* Гурилан бүтээгдэхүүн: талх, гоймонг оруулж тооцно. Шилжүүлэх коэффициент: гоймон=1.0, талх=0.74, нарийн боов=0.64, өндөг=50гр

**Төрөл бүрийн будаа: цагаан будаа, шар будаа, гурвалжин будааг оруулж тооцно.

***Ургамлын тос: наранцэцгийн тос, дал модны тос, рапсын тос, шар буурцагийн тосыг оруулж тооцно.

МЭДЭЭЛЛИЙГ НЭГТГЭСЭН
МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН

СУМЫН ЗАСАГ ДАРГА Д. БОЛДБААТАР